



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН САЙД

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2025.10.17 № 1/4828
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн “Боловсролын бодлого, үйл ажиллагаанд тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг хэрэгжүүлэх талаар асуулга хүргүүлэх тухай” 12 дугаартай албан бичгийг хүлээн авч танилцан, холбогдох хариуг хүргүүлж байна.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 73 тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 4000-5100 төгрөг байхаар тооцож, үүний 1000 төгрөгийг тухайн хүүхдийн эцэг эхээр төлүүлж байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор ерөнхий боловсролын төрийн болон хувийн сургуулийн сурагчийн үдийн хоолны зардлыг 2500-3400 төгрөгөөр тооцон төрөөс олгож байна. Харин хувийн цэцэрлэгт сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа 30,260 хүүхдийн хоолны зардлыг эцэг эх нь бүрэн хариуцаж байна. Иймд хувийн, төрийн цэцэрлэг гэж ялгаварлахгүйгээр цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг адил тэгш олгох талаар Боловсролын яамны зүгээс ямар арга хэмжээ авч байгаа” тухайд

Боловсролын ерөнхий хуулийн 24.1.7-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардлын хувь, хэмжээг Засгийн газраас тогтоож, мөн хуулийн 40.2.9 дэх заалтын дагуу тодорхой хувийг нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хариуцах үүрэг хүлээдэг.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн “Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 218 дугаар тогтоолын 1.2-т заасны дагуу цэцэрлэгийн хүртээмж багатай зарим дүүрэг, хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хамран сургах тойргийн төрийн өмчийн цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийн нөхцөл байдалд үндэслэн нэмэлт элсэлтээр хувийн хэвшлийн цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн хувьсах зардлыг 2 дахин нэмэгдүүлж, хоолны зардлын хамт холбогдох журмын дагуу санхүүжүүлж байна. Тухайлбал, 2025 оны 05 дугаар сарын байдлаар гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянан, зөрүүг тооцон 13,056 хүүхдэд 862.7 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн “Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоол батлагдсан. Уг тогтоолын дагуу нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 4000 төгрөг болгон нэмэгдүүлж, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс 1000 төгрөгийг төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 82.4 тэрбум төгрөг, 2025-2026 оны хичээлийн жилд 131.5 тэрбум төгрөгийг санхүүжүүлж байна.

Улсын Их Хуралд өргөн барьсан боловсролын салбарын 2026 оны төсвийн төсөлд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 122.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр санал хүргүүлсэн болно.

Боловсролын ерөнхий хуулийн 37.2.4-т “төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь үүсгэн байгуулагчийн хөрөнгө, хувьсах зардал, сургалтын төлбөр, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрийн санхүүжилт” гэж, 40.3-д “Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч боловсролын сургалтын байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах бөгөөд гэрээний загварыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална” гэж заасны дагуу Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны А/276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний загвар” батлагдсан. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээнд хүүхдийн хоолны төлбөртэй асуудлыг тусгадаг болно.

Боловсролын ерөнхий хуулийн 24.1.7, 38.6, 40.2.9-д, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.1.1-д заасныг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардлын хувь, хэмжээг Засгийн газраас тогтоож, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган улсын төсвөөс санхүүжүүлж байна.

Хоёр. “Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт заасны дагуу зөвхөн төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургуулийн багш болон ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж авах, нэг хүүхэд нь тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн их, дээд сургуульд үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцах боломжийг төрөөс олгож байна. Харин төрийн өмчийн их, дээд сургуулийн багш, түүнчлэн хувийн хэвшлийн бүх шатны боловсролын байгууллагын багш нар багшийн нийгмийн баталгааг хангах төрийн энэ бодлогын гадна үлдээд байна. Иймд боловсролын салбарт ажиллаж байгаа нийт багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, хөгжлийг дэмжих талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар, тэр тусмаа төрийн өмчийн их, дээд сургуульд ажиллаж байгаа

багшийн нийгмийн баталгааг хангах талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” тухайд

Дээр дурдсанчилан төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь үүсгэн байгуулагчийн хөрөнгө, хувьсах зардал, сургалтын төлбөр, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрийн санхүүжилт байдаг.

Өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид олгох хувьсах зардлыг төрөөс санхүүжүүлдэг. Ингэхдээ боловсролын хууль тогтоомжид заасны дагуу үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгож байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн “Шалгуур батлах тухай” А/64 тушаалын хавсралтаар “Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд улсын төсвөөс хувьсах зардлын санхүүжилт олгох гэрээний үр дүнгийн шалгуурыг үнэлэх аргачлал”-ыг баталсан. Энэхүү аргачлалын дагуу гэрээний биелэлт, үр дүнгийн үнэлгээг үндэслэн гүйцэтгэлийн үр дүнг санхүүжүүлэх хувь хэмжээг тогтоосон.

Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын нийт 189 сургуулиас 166 сургуульд хувьсах зардлын санхүүжилт олгож байна. 2025 оны эхний хагаст хувьсах зардлын санхүүжилтийг сар бүрийн хүүхдийн тооны ирцийн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилийн 80 хувь буюу 19,8 тэрбум төгрөгийн санхүүжилт, үлдсэн 20 хувийн санхүүжилтийг гэрээний хэрэгжилтийг үндэслэн нийт 21.7 тэрбум төгрөг олгосон.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар батлагдсан Боловсролын ерөнхий хуулийн 37.2.2 дахь заалтын дагуу төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага улсын төсөв, сургалтын төлбөр, эндаументын сан болон эрдэм шинжилгээ, инновацын төсөлт ажлын санхүүжилт гэсэн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэртэй байхаар заасан.

Дээд боловсролын тухай хуулийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс үзүүлэх дэмжлэгт тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагчид олгох сургалт, судалгааны тэтгэлэг; улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдол бүхий Засгийн газрын захиалгат судалгаа шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт болон инновацын үйл ажиллагааны зардал; төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардал ордог.

Дээрх эрх зүйн зохицуулалтын дагуу дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолоор баталсан “Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд 2024–2025 онд нийт 10,045 суралцагчид нийтдээ 22.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Мөн Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 164 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлэх

журам" батлагдсан. Журмын дагуу 2025 онд 5.7 тэрбум төгрөгийн тогтмол зардал олгохоор шийдвэрлэсэн.

Гишүүний асуулгад дурдсан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн нийгмийн баталгаатай холбоотой харилцааг Дээд боловсролын тухай хуулийн 7.1-д дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн нийгмийн баталгаа, 17.2-т дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тухайн ажиллаж байгаа байгууллагаас үзүүлэх дэмжлэгийн талаар зохицуулсан бөгөөд багшийн нийгмийн баталгаа, дэмжлэгийг дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод журмаар зохицуулахаар заасан.

Мөн Боловсролын ерөнхий хуулийн 13.3.5 дахь хэсэгт заасны дагуу дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу тэтгэмжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгодог.

Боловсролын яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулдаг хамтын хэлэлцээрт салбарын багш, ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, хөдөлмөрийн зохион байгуулалт, хөдөлмөрийн норм, норматив, тариф, цалин хөлсний асуудлыг тусган ажиллаж ирсэн. Тухайлбал, 2024-2026 оны хамтын хэлэлцээрт "Төрийн өмчийн их сургуулийн багш, ажилтан нь тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг хүрсэн түвшнээс бууруулахгүйгээр олгох асуудлыг холбогдох хууль, дүрэм, журамд үндэслэн Хамтын гэрээгээр зохицуулна" гэж заасан. Энэхүү зохицуулалтын дагуу төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагууд байгууллагынхаа үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан гэрээний дагуу зохицуулдаг. Тухайлбал, Монгол Улсын Боловсролын их сургууль, өндөр насны тэтгэвэрт гарахад олгох дэмжлэгийн асуудлыг тус гэрээнд тусган шийдвэрлэж байна.

Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын нийгмийн баталгаа, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой нэмэгдлийг улсын төсвөөс олгох эрх зүйн зохицуулалт байхгүй бөгөөд дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ур чадварыг олон улсын түвшинд хүргэж, боловсролын чанарыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын 40 багшийг гадаадын их сургуульд суралцуулах ажлыг зохион байгуулах;

- 2025-2026 оны хичээлийн жилд багш нарын заах арга зүй, судалгааны ур чадварыг сайжруулах модуль сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх;

- Багш, судлаачдыг гадаадын их сургуулийн ахисан түвшний сургалтад хамруулах, судалгааны тэтгэлэгт хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх;

- Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийг дэмжих, туршлага судлуулах зорилгоор дотоод, гадаадын их сургуулиуд хоорондын багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

- Багш нарыг эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа тууштай хийх боломжоор хангаж, шаардлагатай сургалтын болон судалгааны орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, судлаачдын бүтээлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, өндөр зэрэглэлийн сэтгүүлд хэвлүүлэхийг урамшуулан, бүтээлийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.



П.НАРАНБАЯР